

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 11 дугаар сарын 1-ний өдөр

№

Улаанбаатар хот

**Захиалагч:** Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургуулийн захирал Гэндэн овогтой Ганцэцэг **Гүйцэтгэгчийг төлөөлж:** Катасис ХХК – ийн захирал Б.Алтанхуяг /цаашид “талууд” гэх/, Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон “Шведийн музейд хадгалагдаж байгаа монгол ардын мартагдсан дуу, хөгжмийг уран бүтээлийн эргэлтэд оруулах” нь төслийн 14 дуу, 8 хөгжмийн бүтээлийн хоолойн бичлэг болон микс мастерингийн ажлыг гүйцэтгэх/цаашид “ажил” гэх/ талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэнэ.
- 1.2 Ажил гүйцэтгэх явцад түүний санхүүжилтын хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарвал талуудын хооронд нэмэлт гэрээ хэлцэл байгуулна.

### Хоёр. Төлбөр тооцоо

- 2.1 Ажлын нийт зардал 5,500,000/Таван сая таван зуун мянган/ төгрөг байна.
- 2.2 Санхүүжилтийг ажлыг хүлээлгэн өгсөн акт дүгнэснээр ажлын 3 хоногийн дотор Катасис ХХК-ний Худалдаа Хөгжлийн банкны 499133624 тоот дансанд шилжүүлнэ.

### Гурав. Талуудын үүрэг

- 3.1. Захиалагч дор дурьдсан үүрэг хүлээнэ:
  - 3.1.1. Дуучид, хөгжимчидийг ноот, дууны шүлгээр ханган бичлэгт оруулах.
  - 3.1.2. Ажлын үр дүнг хүлээн авч түүнийг сургалтын урын сан баяжуулахад ашиглах
- 3.2. Гүйцэтгэгч дор дурьдсан үүрэг хүлээнэ:
  - 3.2.2. Ажлыг хугацаанд нь багтааж бүрэн гүйцэтгэх, үр дүнг тоо чанарын хувьд захиалсан түвшингээс нь бууруулахгүйгээр бүтээж бий болгох
  - 3.2.3. Ажлын явцыг 7 хоног тутам захиалагч талд мэдээлж байх
  - 3.2.4. Ажлыг гэрээт хугацаанд гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлнө.
  - 3.2.5. Ажлын үр дүнг CD-д буулган хүлээлгэн өгнө.

### Дөрөв. Талуудын эрх

- 4.1. Захиалагч дор дурьдсан эрх эдэлнэ:
  - 4.1.1 Гэрээний шаардлагыг хангаагүй үр дүнг хүлээж авахгүй байх, уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсвэл олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх, арга хэмжээ авах

- 4.1.2 Ажлын үр дүн нь хэрэгцээ шаардлагыг хангаахааргүй төлөвтэй байгаа тохиолдолд санхүүжилтыг зогсоох, буюу шинэчлэх, гэрээг цуцлах асуудлыг тавьж шийдвэрлүүлэх

- 4.2. Гүйцэтгэгч дор дурьдсан эрх эдэлнэ.
  - 4.2.1 Ажлыг гүйцэтгэх нөхцөл бололцоогоор бүрэн хангахыг шаардах,
  - 4.2.2 Ажил гүйцэтгэх явцад түүний санхүүжилтын хэмжээг нэмэгдүүлэх /хорогдуулах/ зайлшгүй шаардлага гарвал уг асуудлыг захиалагчтай харилцан тохиролцоно.

### Тав. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Гүйцэтгэгч, төслийн удирдагч нар гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч байгууллага нь энэхүү гэрээг үндэслэж хариуцлага тооцно.
- 5.2 Төсөл хэрэгжүүлж буй бүс нутагт ган зуд болон байгалийн гэнэтийн аюул тохиолдсон, гоц халдварт өвчин гарсан зэрэг байгалийн болон биологийн эрсдэлийн улмаас төслийн явц удааширсан, хүрэх түвшин буурсан зэрэг хүндэтгэх шалтгааныг харгалзана.
- 5.3 Захиалагч, гүйцэтгэгч нар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд аль буруутай тал гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.

### Зургаа. Бусад зүйл


- 6.1. Ажил гүйцэтгэх, санхүүжүүлэх, түүний үр дүнг баталгаажуулах, үнэлэх хүлээлгэн өгөх, үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд шилжүүлэх, ашиглахыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж гаргасан бусад дүрэм, журам, заавар, аргачиллын хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- 6.2. Энэхүү гэрээний эхийг 2 хувь үйлдэж гэрээлэгч талууд тус бүр нэг хувийг хадгалав.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Захиалагчийг төлөөлж:**  
СУИС-ийн Хөгжмийн урлагийн  
сургуулийн захирал

  
Г. Ганцэцэг

СУИС-ийн Хөгжмийн урлагийн  
сургуулийн тэргүүлэх  
профессор

  
С. Соронзонболд  
(доктор, дэд профессор)

**Гүйцэтгэгчийг төлөөлж:**  
Катасис ХХК-ийн захирал

  
Б. Алтанхуяг  
ХХК  
ТТА8987-2-5195269